**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 12 № 01/18 ДУА-2018/24/СТА-ТНЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад нүүрсний хөнгөлөлтийн үнийг Төрийн бус байгууллагад шилжүүлж түлш халаалтын зардлаар тайлагнасан нийт 1,121,670.00 / *нэг сая нэг зуун хорин нэгэн мянга зургаан зуун дал*/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/ мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх*/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /*Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж , Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн*/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн хөрөнгийгзориулалт бусаар хяналтгүй зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох, цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах;

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянжаргалан сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Доржмаа, нягтлан бодогч Ц.Наранжаргал нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН**[1] **:**

АУДИТОР Б.ГАНТУЯА

**ЗӨВШӨӨРСӨН:**

ДАРГА Д.ДОРЖМАА

НЯГТЛАН БОДОГЧ Ц.НАРАНЖАРГАЛ

4817114213
ЗЮА0009 9033475

[1] *Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/*